



“КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН

2023 оны хэрэгжилтийн
үнэлгээний тайлан

Улаанбаатар хот
2024 оны 06 дугаар сарын 26



1. Үнэлгээний зорилго

- 1.1. Энэхүү үнэлгээний зорилго нь “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг үнэлэх, компанийн засаглалын тогтолцоонд тулгарч буй асуудлыг тодорхойлох, түүнд үндэслэн заавар, зөвлөмжийг боловсруулан хүргүүлж, мөрдүүлэх замаар тухайн компанийн засаглалын түвшинг сайжруулахад оршино.
- 1.2. “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн зайны үнэлгээг компанийн төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-өөс томилогдсон холбогдох эрх бүхий албан тушаалтан уг кодексийн хавсралт болох асуулгын маягтын дагуу гүйцэтгэж, оноогоор үнэлнэ. Компанийн ирүүлсэн зайны үнэлгээг баримтад үндэслэн үнэлгээний хяналтын оноо болон хувиар нэгдсэн дүнг тооцно.
- 1.3. Компанийн нэгдсэн дүнг тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлтэй холбоотой шийдвэр гаргах, салбарын компанийн засаглалын тухайн үеийн нөхцөл байдлыг тодорхойлох болон эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр дүн шинжилгээ хийх, мөн компанийн засаглалын түвшингийн нэгдсэн судалгаа гаргаж олон нийтэд мэдээлэл өгөх зорилгоор ашиглана.
- 1.4. Үнэлгээний дүнг үндэслэн компанид тухайлан зөвлөмж, үүрэг, даалгаврыг хүргүүлэх ба тэдгээрийн биелэлтээр зайны үнэлгээний ахиц дэвшлийг тодорхойлно.
- 1.5. Үнэлгээгээр эрсдэлтэй гэж дүгнэгдсэн, эсхүл үнэлгээг Хороо болон бирж, мэргэжлийн холбооноос тухай бүр шаардсан хугацаанд ирүүлээгүй тохиолдолд “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг хангалтгүй гэж тооцно.

2. Үнэлгээний бүтэц

“Компанийн засаглалын кодекс”-ийн үнэлгээний загвар нь нийт 36 асуулга бүхий дараах бүтэцтэй тайлан байна. Үүнд:

№	Гарчиг	Авбал зохих нийт оноо	Үнэлсэн оноо	Хяналтын оноо	Үнэлгээний хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	12		100%
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	10		100%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод байдал	6	6		100%
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	6		100%
5	Эрсдэлийн удирдлага	8	8		100%
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	6		100%
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	8		100%
8	Компанийн соёл	6	6		100%
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	10		100%
Нэгдсэн дүн		72	72		100%

3. Үнэлгээний аргачлал

- 3.1. Асуулга тус бүрийн хувьд бүрэн хэрэгжүүлсэн, эсхүл үндэслэл бүхий тайлбар гаргасан 2, хэсэгчлэн хэрэгжүүлсэн, эсхүл хугацаа бүхий хэрэгжүүлэх арга

хэмжээ, зорилтоо тайлбарласан 1, үнэлгээ ирүүлээгүй бол 0 гэсэн оноогоор тус тус үнэлэх ба хэрэгжилт болон тайлбарыг тус бүрээр нь оруулна.

3.2. Үнэлгээний нэгдсэн дүнд үндэслэн тухайн байгууллагын “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг дараах байдлаар үнэлнэ:

3.2.1. авбал зохих нийт онооны 90 хувь болон түүнээс дээш байвал засаглал хэвийн буюу эрсдэлгүй;

3.2.2. 70-89 хувь байвал дунд засаглалтай буюу цаашид эрсдэл үүсч болзошгүй тул зөвлөмж хүргүүлэх;

3.2.3. 50-69 хувь байвал хангалтгүй засаглалтай буюу эрсдэлтэй тул зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн;

3.2.4. 49 болон түүнээс доош хувьтай бол муу засаглалтай буюу үйл ажиллагаа нь өндөр эрсдэлтэй тул зохицуулалтын арга хэмжээ авах шаардлагатай.

**ХАСБАНК ХК (“ХАСБАНК”)-ИЙН
“КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН 2023 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

"Компанийн засаглалын кодекс"-ийн зарчмын зүйл тус бүрээр үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайланг дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэнэ.

Кодексийн хэрэгжилтийг олон улсад түгээмэл тогтсон "Хэрэгжүүл, эсвэл тайлбарла" гэсэн зарчмын дагуу тайлагнахдаа кодекс дурдсан зарчмын зүйл тус бүрээр биелүүлсэн эсэх, биелүүлээгүй бол яагаад биелүүлээгүй, түүнийг орлох бүтэц, зохион байгуулалтын ямар арга хэмжээ авсныг тайлбар хэсэгт нарийвчлан тайлбарлана.

Нэр томъёоны тайлбар:

ТУЗ - Төлөөлөн удирдах зөвлөл

ЗНДЦУХ - Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо

АХ - Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо

ЭУХ - Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо

Засаглалын төлөвлөгөө - ХасБанк нь Компанийн засаглалын кодекс тусгасан удирдамжид өөрийн компанийн засаглалын үйл ажиллагаагаа уялдуулан удирдах зорилгоор 2023 оны 7 сарын 07-ны өдөр “Засаглалын төлөвлөгөө 2023-2026”-г баталсан. Уг төлөвлөгөөнд цаг хугацааны хувьд нэн даруй боловсруулах боломжгүй бичиг баримтуудыг боловсруулан батлах хугацаа болон нэн даруй биелүүлэх боломжгүй шаардлагыг хэрэгжүүлсэн байх хугацааг тус тус тогтоосон.

НЭГДҮГЭЭР ЗАРЧИМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Төлөөлөн удирдах зөвлөл нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна.

№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар	Оноо	Хувь
1	1.1. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмаар төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.	Бүрэн хэрэгжүүлсэн.	ХасБанк нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг 2023 оны 7 сарын 07-ны өдөр шинэчлэн баталсан. Тус журмын 5, 6 болон 13 дугаар зүйлүүдэд ТУЗ-ийн дарга, гишүүд болон нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулсан бөгөөд түүнийг өөрийн цахим хуудаст байршуулсан. Мөн ТУЗ-ийн 2023 оны Үйл ажиллагааны тайланг ХасБанкны 2023 оны Жилийн тайланд тусгасан бөгөөд ХасБанкны 2023 оны Жилийн тайланг өөрийн цахим хуудаст байршуулсан.	2	

2	<p>1.2. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна.</p>	<p>Бүрэн хэрэгжүүлсэн.</p>	<p>ХасБанк нь түүний алсын хараа, эрхэм зорилго, стратегийн зорилгод нийцүүлэн, стратегийн удирдлага, хяналтыг хэрэгжүүлэх, нийт хувьцаа эзэмшигч, оролцогч талуудын эрх ашгийг хамгаалах, дэмжих, ТУЗ-ийн үндсэн үүргийг гүйцэтгэхэд шаардагдах зохих ур чадвар, мөн чанар бүхий гишүүдээр ТУЗ-өө бүрдүүлэх зорилгоор “ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх ерөнхий журам”-ыг 2011 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр анх удаа баталж, улмаар хэд хэдэн удаа нэмэлт өөрчлөлт оруулах болон шинэчлэн найруулах зэргээр сайжруулан үйл ажиллагаандаа мөрдөж ирсэн. Улмаар ХасБанк ХК болсонтой холбоотойгоор 2023 оны 7 сарын 07-ны өдөр шинэчлэн баталсан бөгөөд түүний дагуу ТУЗ-ийн шинэ гишүүдийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж байна. Мөн, ТУЗ-ийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах үүднээс ТУЗ-ийн гишүүний залгамж халааны төлөвлөгөөг жил бүр хэлэлцдэг. Уг төлөвлөгөө хэлэлцэх процессийг журамлах зорилгоор “ТУЗ-ийн гишүүний залгамж халааг бэлдэх бодлого”-ыг мөн 2025 оны II дугаар улирал гэхэд боловсруулан баталсан байхаар ХасБанкны Засаглалын төлөвлөгөө 2023-2026 баримт бичгийн 10 дугаар зүйлд тусгасан.</p>	2	
3	<p>1.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, өөрийн цахим хуудсанд байршуулна.</p>	<p>Бүрэн хэрэгжүүлсэн.</p>	<p>Жилийн үйл ажиллагааны тайланг ХасБанк ХК-ийн цахим хуудаст байршуулсан. Уг тайланд ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг тусгасан. Мөн ТУЗ нь өөрийн болон ТУЗ-ийн дэргэдэх хороод, ТУЗ-ийн дарга, гишүүдийн 2023 оны ажлын гүйцэтгэлийн үнэлгээг хийж гүйцэтгэн, гүйцэтгэлийн үнэлгээний процессийг илүү сайжруулах зорилгоор ТУЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, ТУЗ-ийн үнэлгээний журмын шинэчилсэн найруулгыг ТУЗ-ийн 2024 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн R-2024-31 тоот тогтоолоор баталсан.</p>	2	

4	<p>1.4. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримт бичигтэй байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэр зэрэг асуудлыг тусгана.</p>	<p>Хэрэгжүүлсэн. Үндэслэл бүхий тайлбарыг харна уу.</p>	<p>ХасБанкны ТУЗ-ийн дэргэдэх байнгын хороод болох ЗНДЦУХ, АХ, ЭУХ тус бүр нь өөрийн холбогдох дүрмүүдийг баримтлан үйл ажиллагаагаа явуулдаг. Тус дүрмүүдэд хороодын бүтэц, бүрэлдэхүүнийг нарийвчлан заасан. Гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлагыг ЗНДЦУХ-ны дүрмийн 2.1 болон АХ-ны дүрмийн 2.1 дүгээр зүйлүүдэд тус тус тусгасан. Хүйсийн тэнцвэрийн тухайд, АХ-ны дүрмийн 2.1-д “Гишүүдийн бүрэлдэхүүнд хүйсийн тэгш байдлыг хангах эсхүл Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан Компанийн засаглалын кодекст заасан аль нэг хүйсийн эзлэх доод хэмжээг хангахыг эрмэлзэнэ” гэж тусгасан. 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар ХасБанкны ТУЗ дэх эмэгтэй гишүүдийн эзлэх хувь 27%-тай байна. Энэ асуудлаар ХасБанкны Засаглалын төлөвлөгөө 2023-2026 баримт бичгийн 2 дугаар зүйлд, 2025 оны II дугаар улирал гэхэд ТУЗ дэх хүйсийн төлөөллийг 30%-иас дээш хувьд хүргэнэ гэж заасны дагуу уг хугацаанд Компанийн засаглалын кодекст заасан шаардлагыг давуулан биелүүлэхээр зорьж байна.</p>	2	
5	<p>1.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.</p>	<p>Бүрэн хэрэгжүүлсэн.</p>	<p>ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг компанийн засаглалын сургалтад нэн тэргүүнд хамруулж Монгол Улсын Компанийн тухай хууль, компанийн засаглалын онцлогийг таниулах сургалтыг зохион байгуулдаг. 2023 оны тайлант хугацаанд нийт 3 нэр дэвшигчийг Засаглалын сургалтад хамруулсан байна. Мөн, ТУЗ-ийн гишүүн анх томилогдмогц түүнд (а) ХасБанкны онцлогийг таньж мэдэхэд зориулсан багц материал, үүнд Өмнөх оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлан, өмнөх хурлын тэмдэглэл зэрэг бичиг баримтууд, (б) өөрийн үйл ажиллагааг зохистой удирдан явахад зориулж ТУЗ-ийн гишүүд болон ажилтнуудын ёс зүйн кодекс ба сонирхлын зөрчлийн ерөнхий журам, ХасБанкны Засаглалын кодекс, ХасБанк ХК-ийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, Дотоод мэдээлэл эзэмшигчийн арилжааны ерөнхий журам,</p>	2	

			<p>Монголбанкнаас баталсан компанийн засаглалын баримт бичгүүд зэрэг ТУЗ-ийн үйл ажиллагаанд хамаарах бусад бичиг баримтуудыг хүргүүлдэг. ТУЗ-ийн гишүүд нь ГЗ-тай тохиролцон, Банкны өдөр тутмын үйл ажиллагаанд саад болохгүй байдлаар Банкны удирдлагуудтай уулзалт зохион байгуулж асууж тодруулах, мэдээлэл авах нөхцөл боломжоор хангагддаг.</p> <p>Түүнчлэн, ТУЗ-ийн 2024 оны сургалтын хөтөлбөрийг ТУЗ-ийн 2024 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн R-2024-30 тоот тогтоолоор баталж, тус хөтөлбөрийн дагуу сургалт зохион байгуулж, ТУЗ-ийн гишүүдийг хамруулан ажиллаж байна.</p>		
6	1.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн.	<p>ХасБанк ХК-ийн Дүрмийн 8.44.5 дахь заалт болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 13.1 дэх хэсэгт тус тус заасны дагуу ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь банкны эрх бүхий албан тушаалтан болохын хувьд ТУЗ-ийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар хариуцлага хүлээнэ. ТУЗ-ийн нарийн бичгийн даргын 2023 онд хийж гүйцэтгэсэн ажил ХасБанкны 2023 оны Жилийн тайланд тусгагдсан бөгөөд ХасБанкны 2023 оны Жилийн тайланг өөрийн цахим хуудаст байршуулсан болно.</p>	2	
Үнэлсэн оноо				12	100%
ХОЁРДУГААР ЗАРЧИМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ					
Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ.					
7	2.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болоод төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.	Хэрэгжүүлсэн. Үндэслэл бүхий тайлбар харна уу.	<p>ХасБанкны Засаглалын төлөвлөгөө 2023-2026 баримт бичгийн 3 болон 4 дүгээр зүйлүүдэд 2026 оны IV дүгээр улирал гэхэд ТУЗ-ийн даргаар хараат бус гишүүнийг томилох болон ТУЗ-ийн гишүүдийн олонхийг хараат бус гишүүдээр бүрдүүлэх зорилтыг тусгасан.</p>	2	
8	2.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь төлөөлөн	Бүрэн хэрэгжүүлсэн.	<p>ТУЗ-ийн дэргэдэх АХ-ны дүрэм, Дотоод аудитын бодлогыг 2023 оны 7 сарын 07-ны өдөр шинэчлэн баталсан бөгөөд түүнийг цахим хуудастаа байршуулсан. АХ-ны даргаар ТУЗ-ийн дарга бус, хараат бус гишүүн ажиллаж байна. АХ-ны</p>	2	

	<p>удирдах зөвлөлийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.</p>		<p>хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцдог. Энэ талаар АХ-ны дүрмийн 2.5-д “Банкны гүйцэтгэх удирдлага, ажилтнуудыг зөвхөн тус Хорооны хүсэлтээр хуралдаанд оролцуулна” гэж тусгасан.</p> <p>Аудитын хорооны бүтэц, бүрэлдэхүүнийг ТУЗ-ийн 2024 оны ХасБанкны ТУЗ-ийн дэргэдэх байнгын хороодын бүрэлдэхүүнийг батлах тухай R-2024-23 тоот тогтоолоор томилсон.</p>		
9	<p>2.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.</p>	<p>Хэрэгжүүлсэн. (үндэслэл бүхий тайлбарыг харна уу.)</p>	<p>ЗНДЦУХ-ны дүрмийг 2023 оны 7 сарын 07-ны өдөр шинэчлэн баталсан бөгөөд түүнийг цахим хуудаастаа байршуулсан. Мөн, цалин, урамшууллын бодлогын баримт бичгүүд болох ТУЗ-ийн цалин хөлс болон нөхөн төлбөрийн ерөнхий журмыг R-2023-33 тоот тогтоол, Урт хугацаат урамшууллын хөтөлбөрийн бодлогыг R-2024-08 тоот тогтоол, Тэтгэврийн нэрийн дансны ерөнхий журмыг R-2018-26 тоот тогтоолоор тус тус баталсан.</p> <p>ЗНДЦУХ-ны дарга Майкл Мадден нь ТУЗ-ийн дарга бус болно. Тэрээр тус Хорооны даргаар 2019 оноос хойш ажиллаж буй бөгөөд хариуцсан асуудлаар хамгийн туршлагатай, манлайлагчийн түвшинд ажиллаж буй болно. ТУЗ хуралдаад хараат бус гишүүдэд уг ажлыг шилжүүлэхэд тодорхой бэлтгэл шаардлагатай гэж үзсэн тул ХасБанкны Засаглалын төлөвлөгөө 2023-2026 баримт бичгийн 6 дугаар зүйлд ЗНДЦУХ-ны даргад хараат бус гишүүдийг бэлтгэж, бэлтгэл хангагдсаны дараа уг шилжилтийг хийхээр тусгасан. ЗНДЦУХ-ны нарийн бичгийн даргын үүргийг Хууль хариуцсан захирал, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга гүйцэтгэдэг. Тэрээр албан тушаалын хувьд гүйцэтгэх удирдлагад хамаардаг хэдий ч ЗНДЦУХ-ны нарийн бичгийн даргын хувиар ЗНДЦУХ-ны хурлуудад оролцох шаардлагатай болдог. Гэхдээ гүйцэтгэх удирдлагын цалин урамшуулал, залгамж халаа зэрэг асуудлын үеэр гүйцэтгэх удирдлагын ямар ч албан тушаалтан оролцдоггүй ба гишүүд хаалттай хуралддаг.</p>	2	

			ЗНДЦУХ-ны бүтэц, бүрэлдэхүүнийг ТУЗ-ийн 2024 оны ХасБанкны ТУЗ-ийн дэргэдэх байнгын хороодын бүрэлдэхүүнийг батлах тухай R-2024-23 тоот тогтоолоор томилсон.		
10	2.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.	Хэрэгжүүлсэн. (үндэслэл бүхий тайлбарыг харна уу.)	ЗНДЦУХ-ны дүрмийг 2023 оны 7 сарын 07-ны өдөр шинэчлэн баталсан бөгөөд түүнийг цахим хуудастаа байршуулсан. ЗНДЦУХ нь гүйцэтгэх удирдлагын залгамж халааны төлөвлөгөөний хяналтыг жил бүр хийдэг. Уг хурал хаалттай болдог бөгөөд зөвхөн Хорооны хүсэлтээр гүйцэтгэх удирдлага тайлбар өгөх зорилгоор оролцдог. Бодлогын тухайд, ХасБанкны Засаглалын төлөвлөгөө 2023-2026 баримт бичгийн 9 болон 10 дугаар зүйлд гүйцэтгэх удирдлагын залгамж халааны бодлогыг 2024 оны III улирал, ТУЗ-ийн гишүүдийн залгамж халааны бодлогыг 2025 оны II дугаар улиралд боловсруулж батлуулахаар тусгасан. ЗНДЦУХ-ны дарга Майкл Мадден нь ТУЗ-ийн дарга бус болно. Тэрээр тус Хорооны даргаар 2019 оноос хойш ажиллаж буй бөгөөд хариуцсан асуудлаар хамгийн туршлагатай, манлайлагчийн түвшинд ажиллаж буй болно. ТУЗ хуралдаад хараат бус гишүүдэд уг ажлыг шилжүүлэхэд тодорхой бэлтгэл шаардлагатай гэж үзсэн тул ХасБанкны Засаглалын төлөвлөгөө 2023-2026 баримт бичгийн 6 дугаар зүйлд ЗНДЦУХ-ны даргад хараат бус гишүүдийг бэлтгэж, бэлтгэл хангагдсаны дараа уг шилжилтийг хийхээр тусгасан. ЗНДЦУХ-ны бүтэц, бүрэлдэхүүнийг ТУЗ-ийн 2024 оны ХасБанкны ТУЗ-ийн дэргэдэх байнгын хороодын бүрэлдэхүүнийг батлах тухай R-2024-23 тоот тогтоолоор томилсон.	2	
11	2.5. Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай	Бүрэн хэрэгжүүлсэн.	ХасБанкны ТУЗ нь өөрийн дэргэд ЗНДЦУХ, АХ болон ЭУХ гэсэн 3 байнгын хороодтойгоор үйл ажиллагаа явуулж буй бөгөөд хороо тус бүр өөрийн дүрмийн дагуу үйл ажиллагаагаа явуулдаг. Хороодын дүрмийг өөрийн цахим хуудастаа байршуулсан. Хороодын бүрэлдэхүүнд тавигдах	2	

	мэдлэг, ур чадвар, ажлын туршлага бүхий бүрэлдэхүүнтэй байна.		шаардлагыг ЗНДЦУХ-ны дүрмийн 2.1 болон АХ-ны дүрмийн 2.1-д тус тус нарийвчлан тусгасан.		
Үнэлсэн оноо				10	100%
ГУРАВДУГААР ЗАРЧИМ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ					
Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана.					
12	3.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Бүрэн хэрэгжүүлсэн.	ХасБанк нь өөрийн хувьцаа эзэмшигчид болон эрх бүхий байгууллагуудад банкны талаарх мэдээллийг холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагын дагуу ил тод тайлагнан, мэдээлэх зорилгоор “Мэдээллийг ил тод болгох ерөнхий журам”-ыг 2023 оны 7 сарын 07-ны өдөр шинээр баталсан бөгөөд түүнийг цахим хуудастаа байршуулсан. Тус журмын 1.4-д ТУЗ нь түүний хэрэгжилтэд хяналт тавихаар зохицуулсан.	2	
13	3.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн.	ХасБанк нь үйл ажиллагаагаа хувьцаа эзэмшигчдэд ил тодоор явуулах үүднээс дараах дотоод дүрэм, журам, төлөвлөгөөг өөрийн цахим хуудсын “”Хөрөнгө оруулагчид” цэст байршуулан ажиллаж байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> - ХасБанк ХК-ийн дүрэм; - ТУЗ-ийн дэргэдэх ЗНДЦУХ-ны дүрэм; - ТУЗ-ийн дэргэдэх АХ-ны дүрэм; - ТУЗ-ийн дэргэдэх ЭУХ-ны дүрэм; - Засаглалын төлөвлөгөө 2023-2026; - ХасБанкны Засаглалын кодекс; - ТУЗ-ийн үйл ажиллагааны журам; - ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх ерөнхий журам; - Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах үйл ажиллагааны журам - Мэдээллийг ил тод болгох ерөнхий журам; - Дотоод аудитын дүрэм; - Сонирхлын зөрчилтэй этгээд болон холбогдох этгээдтэй хэлцэл хийх журам; 	2	

			<ul style="list-style-type: none"> - ТУЗ-ийн гишүүд болон ажилтнуудын ёс зүйн кодекс ба сонирхлын зөрчлийн ерөнхий журам; - Шүгэл үлээх бодлого; - Комплаенсийн хөтөлбөр; - ХасБанкны Ногдол ашгийн бодлого зэрэг хамаарна. 		
14	<p>3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.</p>	<p>Бүрэн хэрэгжүүлсэн.</p>	<p>ХасБанк нь санхүү, татварын тайлан, тодруулгуудыг холбогдох хууль, тогтоомж, Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС), зохицуулагч байгууллагын журам, зааварт нийцүүлэн үнэн зөв, материаллаг алдаагүй бэлтгэн, санхүүгийн тайланг олон улсын нэр хүнд бүхий Deloitte, KPMG, EY, PWC зэрэг аудитын байгууллагаар баталгаажуулан тогтоосон цаг хугацаанд багтаан олон нийтэд ил тод тайлагнан ажилладаг. Мөн Санхүүгийн бус тайлан буюу өөрийн үйл ажиллагааны жилийн тайланг жил бүр бэлтгэн олон нийтэд ил тод өөрийн цахим хуудаст байршуулдаг. Энэхүү тайлангаар банк нь тухайн жилийн үйл ажиллагаагаа тайлагнадаг бөгөөд үүнд үйл ажиллагааны үр дүн буюу нийгэм байгаль орчинд үзүүлэх нөлөө, нийгмийн хариуцлага зэрэг агуулга багтана.</p>	2	
Үнэлсэн оноо				6	100%
ДӨРӨВДҮГЭЭР ЗАРЧИМ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО Төлөөлөн удирдах зөвлөл нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана.					

15	4.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, хөндлөнгийн аудиторыг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, журмын хэрэгжилтэд хяналт тавина.	Бүрэн хэрэгжүүлсэн.	АХ-ны дүрмийн 3.1 дүгээр зүйлийн В хэсэгт хөндлөнгийн аудитортой харьцах, чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар заасан. Үүнд, АХ нь i) хатуу шалгуурыг баримтлан хөндлөнгийн аудиторыг сонгон шалгаруулах, түүнтэй байгуулсан гэрээг үргэлжлүүлэн сунгах, дуусгавар болгох зэрэг асуудлыг ТУЗ-д зөвлөмж болгон батлуулах, ii) аудитын үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангахын тулд хөндлөнгийн аудитор хараат бус байдлыг хангах, iii) дотоод аудитын ажлын уялдааг харгалзан хөндлөнгийн аудитын санал болгох бүх төрлийн аудитын үйлчилгээ буюу аудитын хамрах хүрээ, арга аргачлал зэргийг хянан батлах, iv) хөндлөнгийн аудиторуудын мэргэшил, гүйцэтгэл, хараат бус байдлыг жилд нэгээс доошгүй удаа үнэлэх, v) шаардлагатай гэж үзсэн асуудлаар хөндлөнгийн аудитортой тогтмол уулзалт тусгайлан хийх зэргийг тусгасан. Дүрмийг xacbank.mn цахим хуудаст байршуулсан.	2	
16	4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.	Бүрэн хэрэгжүүлсэн.	АХ-ны дүрмийн 3.1.В.г-д “Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгнө” гэж заасан. Үүний дагуу 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хөндлөнгийн аудиторыг оролцуулж, хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл авах эрхийг ханган ажилласан.	2	
17	4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж тэдгээрт орсон өөрчлөлтийг тухай бүр мэдэгдэнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн.	ХасБанкны дотоод аудитын тогтолцоо, түүний бүтцийн талаарх мэдээллийг ХасБанкны 2023 оны Жилийн тайланд тусгаж, ХасБанкны 2023 оны Жилийн тайланг цахим хуудастаа байршуулсан. Мөн түүний чиг үүргийн талаарх мэдээлэл нь “Хөрөнгө оруулагчид” цэст байршуулсан “Дотоод аудитын дүрэм”-д дэлгэрэнгүй тусгагдсан.	2	
Үнэлсэн оноо				6	100%
ТАВДУГААР ЗАРЧИМ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА					

Төлөөлөн удирдах зөвлөл нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина.

18	<p>5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.</p>	<p>Бүрэн хэрэгжүүлсэн.</p>	<p>ХасБанкны ТУЗ нь өөрийн дэргэдэх ЭУХ-гоор дамжуулан банкны эрсдэлийн удирдлагын тогтолцоо, хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээг тогтоох, эрсдэлийг үр дүнтэй удирдах бусад бодлого, баримт бичгийг баталдаг. ТУЗ-ийн дэргэдэх ЭУХ нь улирал тутамд хуралдаж ТУЗ-өөс өгсөн эрх хэмжээний хүрээнд эрсдэлийн удирдлага болон хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэмжээний хэрэгжилтэнд хяналт тавьж, ТУЗ-д тайлагнадаг. Гүйцэтгэх удирдлагын дэргэдэх ЭУХ нь сар бүр хуралдаж банкны эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлдэг бол Эрсдэл хариуцсан захирал нь эрсдэлийн удирдлагын өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллах чиг үүрэгтэй.</p> <p>ХасБанк нь эрсдэлийн удирдлагыг хамгаалалтын гурван бүсийн зарчимд тулгуурлан хэрэгжүүлдэг бөгөөд нэгдүгээр бүс нь эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх, хоёрдугаар бүс нь эрсдэлийн удирдлагын хяналтын, гуравдугаар бүс нь эрсдэлийн удирдлага, эрсдэлийн удирдлагын хяналтад хараат бус дүгнэлт өгч ажилладаг. Энэ үйл ажиллагаанд ТУЗ-өөс баталсан “Эрсдэлийн удирдлагын нэгдсэн бодлого”-ыг баримталдаг.</p> <p>ЭУХ-ны бүтэц, бүрэлдэхүүнийг ТУЗ-ийн 2024 оны ХасБанкны ТУЗ-ийн дэргэдэх байнгын хороодын бүрэлдэхүүнийг батлах тухай R-2024-23 тоот тогтоолоор томилсон.</p>	2	
19	<p>5.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд</p>	<p>Хэрэгжүүлсэн. (Үндэслэл бүхий тайлбарыг харна уу.)</p>	<p>ТУЗ-ийн дэргэдэх ЭУХ нь нийт 5 гишүүнээс бүрдэнэ. ЭУХ-ны гишүүдийн дийлэнх олонх буюу 3 гишүүн нь хараат бус гишүүн бөгөөд ЭУХ-ны дарга Ив Жако нь ТУЗ-ийн ердийн гишүүн болно. Тэрээр тус Хорооны даргаар 2021 оноос хойш ажиллаж буй бөгөөд хариуцсан асуудлаар хамгийн туршлагатай, манлайлагчийн түвшинд ажиллаж буй болно. ТУЗ хуралдаад хараат бус гишүүдэд уг ажлыг шилжүүлэхэд тодорхой бэлтгэл шаардлагатай гэж үзсэн тул ХасБанкны Засаглалын төлөвлөгөө 2023-2026 баримт бичгийн 6 дугаар</p>	2	

	мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.		зүйлд ЭУХ-ны даргад хараат бус гишүүдийг бэлтгэж, бэлтгэл хангагдсаны дараа уг шилжилтийг хийхээр тусгасан. ЭУХ-ны дүрэм, бүтэц, бүрэлдэхүүнийг өөрийн цахим хуудсын “Хөрөнгө оруулагчид” цэст нийтэлсэн бөгөөд жилийн үйл ажиллагааны тайланд мөн энэ мэдээллийг тусгасан. ЭУХ-ны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар ТУЗ-ийн хараат бус гишүүдийн тайланд тусгасан байдлаар улирал тутам Монголбанкинд хүргүүлж, хагас жил тутам өөрийн цахим хуудсаараа дамжуулан нийтэд тогтмол тайлагнаж байна.		
20	5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.	Бүрэн хэрэгжүүлсэн.	ХасБанк нь өөрийн үйл ажиллагаандаа “Нийгэм болон байгаль орчны бодлого”-ыг мөрдөн ажилладаг бөгөөд тогтвортой хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэгч байгууллагын хувьд банкны үйл ажиллагааны экологи болон нийгэмд үзүүлэх нөлөөг хянах зорилгоор 2002 оноос эхлэн ISO 14001 стандартын дагуу Байгаль Орчин Нийгмийн Хариуцлагын Удирдлагын Тогтолцоог (БОНХУТ) нэвтрүүлэн, тогтмол шинэчлэн ажиллаж байна. Улс орон даяар хэрэгжүүлж буй өөрсдийн үйл ажиллагаанаас нийгэм, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдээллийг системтэйгээр цуглуулж, байгаль орчин, нийгмийн тайланг жилийн эцсийн байдлаар тогтмол бэлтгэж хөрөнгө оруулагчид, зээлдүүлэгчдэд дараа жилийн эхний улиралд багтаан тайлагнадаг. Түүнчлэн Тогтвортой хөгжил, Тогтвортой санхүүжилт, Ногоон санхүүжилтийн талаарх мэдээллийг банкны үйл ажиллагааны жилийн тайлангаар тайлагнаж ирсэн. 2023 оноос эхлэн тусад нь Тогтвортой хөгжлийн тайлан бэлтгэн тайлагнаж эхэлсэн. Энэ хүрээнд Монголын Хөрөнгийн Биржид тус тайланг хугацаанд нь хүргүүлж, цахим хуудсаараа дамжуулан нийтэд мэдээлж байна.	2	
21	5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр	Бүрэн хэрэгжүүлсэн.	ХасБанкны комплаенсийн хяналтыг Комплаенсийн хэлтэс нь Эрсдэл хариуцсан захирлын удирдлагын дор хариуцан хэрэгжүүлдэг. Тус хэлтэс нь үйл ажиллагаандаа бодлого журам болон автоматжуулсан систем, хяналтыг хослуулан	2	

	дүн, хараат бус байдалд төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.		холбогдох эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, хэмжих, бууруулах, тайлагнах арга хэмжээ бүхий “Комплаенсийн хөтөлбөр”-ийг баримталдаг бөгөөд түүнийг өөрийн цахим хуудастаа байршуулсан болно. Хөтөлбөрийн хэрэгжилтийг ТУЗ нь жил тутам хянаж, түүнд өөрчлөлт оруулах эсэхийг шийдвэрлэн ажилладаг.		
Үнэлсэн оноо				8	100%
ЗУРГААДУГААР ЗАРЧИМ. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ					
Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна.					
22	6.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.	Бүрэн хэрэгжүүлсэн.	ХасБанкны хувьцаа эзэмшигчид нь 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр болсон ээлжит хурлаараа ТУЗ-ийн гишүүдийг бүрэн бүрэлдэхүүнээр нь томилохдоо ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээ, олгох давтамжийг ил тод хэлэлцэн баталсан. Хувьцаа эзэмшигчдийн хурлын SR-2024-11 тоот тогтоолоор ХасБанкны ТУЗ-ийн гишүүний хөлсийг шинэчлэн тогтоосон.	2	
23	6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримт бичигт тусгана.	Бүрэн хэрэгжүүлсэн.	ХасБанкны “ТУЗ-ийн гишүүдийн цалин хөлс, нөхөн төлбөрийн ерөнхий журам”-ын 2.5 дахь хэсэгт зааснаар ТУЗ-ийн гишүүнд тухайн жилд олгох цалин хөлс нь түүний оролцох шаардлагатай ТУЗ, түүний хороо болон хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийн бүртгэлээс хамааран тодорхойлогдоно. ТУЗ-ийн гишүүн тус бүрийн хурлын ирц, хуралд оролцсон байдал, ажлын гүйцэтгэлийг Монголбанкнаас баталсан “Банкны зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийн хяналт шалгалтын журам”-ын дагуу ЗНДЦУХ-ноос жил бүр тодорхойлж, ТУЗ болон хувьцаа эзэмшигчдэд тайлагнадаг. ХасБанкны ЗНДЦУХ нь 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр болсон ТУЗ болон хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн гишүүдийн ажлын гүйцэтгэл, хурлын ирц, хуралд оролцсон байдал, ТУЗ-ийн үйл ажиллагааны үр дүн, ажлын гүйцэтгэлийг тийнхүү тайлагнасан.	2	

			Мөн ТУЗ нь ТУЗ-ийн цалин хөлс болон нөхөн төлбөрийн ерөнхий журмыг R-2023-33 тоот тогтоолоор баталсан.		
24	6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.	Бүрэн хэрэгжүүлсэн.	ХасБанкны 2023 оны Жилийн тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал, бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурын талаарх мэдээллийг тусгасан ба өөрийн цахим хуудаст байршуулсан.	2	
Үнэлсэн оноо				6	100%
ДОЛООДУГААР ЗАРЧИМ. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ					
Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ.					
25	7.1. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн.	ХасБанк нь хууль ёсны бөгөөд ёс зүйтэй бизнесийн үйл ажиллагаа явуулах, дотооддоо ёс зүйт зан үйлийн дээд стандартыг баримтлан, ёс зүйд тулгуурласан зан суртахууны соёлыг төлөвшүүлэх зорилгоор баталсан “ТУЗ-ийн гишүүд болон ажилтнуудын ёс зүйн кодекс ба сонирхлын зөрчлийн ерөнхий журам”-аар банкны оролцогч талуудтай харилцах харилцаанд баримтлах ёс зүйн хэм хэмжээг тодорхойлсон. Мөн ХасБанкны толгой компани болох Тэнгэр санхүүгийн нэгдэл ХХК-иас баталсан, тус нэгдэл дэх охин компаниудын хэмжээнд дагаж мөрддөг засаглалын кодексийг ХасБанкны түвшинд буулган “ХасБанкны Засаглалын кодекс”-ийг шинээр баталсан. Уг баримт бичиг нь урт хугацааны, тогтвортой өсөлт хөгжлийн чухал бүрэлдэхүүн болох компанийн засаглалыг сайжруулах зорилготой. Түүний 1-р хэсгийн 1-д банк нь оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллахдаа ил тод, шударга, хариуцлагатай, ёс зүйтэй байх зарчмуудыг баримтлах, 3-р хэсгийн 2-т “санал хураалтад жижиг хувьцаа эзэмшигч, оролцогч талуудын эрхийг онцгойлон харгалзаж үзэх, Монголбанкны журмын дагуу ТУЗ-д хэд хэдэн хараат бус гишүүнийг томилох, холбогдох хууль тогтоомжид заасны дагуу үнэн зөв мэдээллийг тухай бүр авах эрхээ саадгүй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхийг чухалчилна. Бүх хувьцаа эзэмшигчийг эрхээ	2	

			хэрэгжүүлж, шийдвэр гаргахад шаардлагатай буюу хангалттай мэдээллээр хангана” гэж оролцогч талуудын эрх ашгийг хамгаалах талаар зохицуулалтыг тусгасан. Түүнчлэн, ХасБанк нь хувьцаа эзэмшигчтэй тусгай дугаар болон цахим шуудангаар харилцах харилцааг үнэн зөв, ижил жигд, хууль тогтоомжид нийцсэн байдлаар удирдан зохион байгуулах зорилгоор “Хувьцаа эзэмшигчидтэй шууд харилцах ерөнхий журам”-ыг 2023 оны 11 сарын 30-ны өдөр шинээр баталсан. Үүнээс гадна ТУЗ нь Оролцогч талуудтай харилцаж, хамтран ажиллах журмыг R-2024-29 тоот тогтоолоор баталсан.		
26	7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.	Бүрэн хэрэгжүүлсэн.	ХасБанкны 2023 оны Жилийн тайланд банк нь оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан, түүнийгээ хэрхэн хэрэгжүүлсэн талаарх мэдээллийг тусгасан ба өөрийн цахим хуудаст байршуулсан.	2	
27	7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.	Бүрэн хэрэгжүүлсэн.	ХасБанк нь өөрийн xacbank.mn цахим хуудсаар дамжуулан оролцогч талуудад мэдээллийг тогтмол хүргэж, түүний санал, гомдол хэсгээр дамжуулан оролцогч талуудтай харилцан ажиллаж байна. Цахим хуудсын үр дүнг сайжруулах үүднээс оролцогч талуудад мэдээлэл хүргүүлэх зориулалт бүхий тусгайлсан цахим хуудсыг 2024 оны 3 дугаар улирал гэхэд хөгжүүлсэн байхаар ХасБанкны Засаглалын төлөвлөгөө 2023-2026 баримт бичгийн 12 дугаар зүйлд мөн тусгасан.	2	
28	7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.	Бүрэн хэрэгжүүлсэн.	ХасБанк нь 2023 оны 7 сарын 07-ны өдөр шинэчлэн баталсан “Шүгэл үлээх бодлого”-ын дагуу банкны нэр хүнд, бүтээгдэхүүн, үйлчилгээ, өмч хөрөнгө, үйл ажиллагаа, банкны ажилтанд сөргөөр нөлөөлөх аливаа үйлдлийн талаар болон банкны үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн эсхүл зөрчсөн байж болзошгүй аливаа үйлдэл, эс үйлдэл, нөхцөл байдлын талаар банкны эрх бүхий албан тушаалтан болон ажилтны зүгээс ирүүлсэн мэдээллийг шийдвэрлэн ажиллаж байна. Харин	2	

			<p>ажилтнуудын өөр бусад санал, хүсэлт, гомдлыг Хүний нөөцийн удирдлагын газар нь амаар болон бичгээр хүлээн авч, тухай бүр шийдвэрлэн ажилладаг. Ингэхдээ ирүүлсэн мэдээллийн агуулгаас шалтгаалж хяналт шалгалт явуулах, шаардлагатай тохиолдолд өөр бусад нэгжийг татан оролцуулдаг.</p> <p>ХасБанк нь ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд ажилтандаа нэмэлт тэтгэврийн хуримтлал бий болгох үүднээс “Тэтгэврийн нэрийн дансны ерөнхий журам”, ажилтны санхүүгийн хэрэгцээг хангах үүднээс “Ажилтны зээлийн ерөнхий журам”, мэргэжил дээшлүүлэх хүрээнд “ХасБанкны сургалт, хөгжлийн ерөнхий журам” зэргийг тус тус батлан, мөрдүүлж байна.</p>		
Үнэлсэн оноо				8	100%
НАЙМДУГААР ЗАРЧИМ. КОМПАНИЙН СОЁЛ					
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно.					
29	8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор төлөөлөн удирдах зөвлөл нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Бүрэн хэрэгжүүлсэн.	ХасБанк нь хууль ёсны бөгөөд ёс зүйтэй бизнесийн үйл ажиллагаа явуулах зорилгоор дотооддоо ёс зүйт зан үйлийн дээд стандартыг баримтлан, ёс зүйд тулгуурласан зан суртахууны соёлыг төлөвшүүлэх үүднээс “ТУЗ-ийн гишүүд болон ажилтнуудын ёс зүйн кодекс ба сонирхлын зөрчлийн ерөнхий журам”-ыг 2023 оны 7 сарын 07-ны өдөр шинээр баталж, цахим хуудсаараа дамжуулан нийтэд мэдээлсэн. Тус журмын хэрэгжилтэд ТУЗ хяналт тавьдаг.	2	
30	8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг төлөөлөн удирдах зөвлөл, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх "шүгэл үлээгчийн" тогтолцоотой байна.	Бүрэн хэрэгжүүлсэн.	ХасБанк нь банкны нэр хүнд, бүтээгдэхүүн, үйлчилгээ, өмч хөрөнгө, үйл ажиллагаа, банкны ажилтанд сөргөөр нөлөөлөх аливаа үйлдлийн талаар болон банкны үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн эсхүл зөрчсөн байж болзошгүй аливаа үйлдэл, эс үйлдэл, нөхцөл байдлын талаар банкны эрх бүхий албан тушаалтан болон ажилтны зүгээс ирүүлсэн мэдээллийг шийдвэрлэхэд баримтлах “Шүгэл үлээх бодлого”-ыг 2023 оны 7 сарын 07-	2	

			ны өдөр шинэчлэн баталсан (xacbank.mn -ээс үзнэ үү). Энэ журмаар шүгэл үлээгч мэдээлэл ирүүлэх, ирүүлсэн мэдээлэлд үндэслэн хяналт, шалгалтыг явуулах, мэдээлэл ирүүлэгчийн нууцыг чандлан хадгалах зэрэг шүгэл үлээх тогтолцоог бүхэлд нь зохицуулдаг.		
31	8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.	Бүрэн хэрэгжүүлсэн.	“ТУЗ-ийн гишүүд болон ажилтнуудын ёс зүйн кодекс ба сонирхлын зөрчлийн ерөнхий журам”-ын 2 болон 3 дугаар зүйлүүдэд банкны ТУЗ-ийн гишүүн болон ажилтан нь авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх, улс төрийн үйл ажиллагааг дэмжихгүй, хандив өгөхөөс зайлсхийн төвийг сахисан байх суурьтай байх талаар зохицуулсан. Мөн Банк болон түүний эрх бүхий албан тушаалтан, ажилтан, агент, түнш, ханган нийлүүлэгч, зөвлөх, төлөөлөгч, зуучлагчийн хэн нь ч банкны өмнө хүлээсэн албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон банкны нэрийн өмнөөс авлига, хээл хахуулийн зөрчил үйлдэхгүй байх явдлыг хангах зорилгоор “Авлига, хээл хахуулийн эсрэг ерөнхий журам”-ыг 2023 оны 9 сарын 28-ны өдөр шинэчлэн баталсан бөгөөд түүгээр энэ асуудлыг нарийвчлан зохицуулж байна.	2	
Үнэлсэн оноо				6	100%
ЕСДҮГЭЭР ЗАРЧИМ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ					
Компани болон төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана.					
32	9.1. Компани хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудад зориулан өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа дамжуулан тухай бүр хүргэнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн.	ХасБанк нь өөрийн xacbank.mn цахим хуудсаар дамжуулан үйл ажиллагаа, санхүүгийн тайланг улирлаар болон жилээр, засаглалын зохион байгуулалт буюу хувьцаа эзэмшлийн бүтэц, ТУЗ болон түүний хороод, байгууллагын бүтэц, зохион байгуулалт зэрэг холбогдох мэдээллийг хууль тогтоомжид заасан хугацаанд нийтэд мэдээлэн ажиллаж байна. Мөн хууль тогтоомжийн дагуу тухай бүр мэдээлэх мэдээллийг өөрийн цахим хуудсаараа дамжуулан цаг алдалгүй, шуурхай мэдээлж байна.	2	

33	<p>9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба хөрөнгө оруулагчидтай харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.</p>	<p>Бүрэн хэрэгжүүлсэн.</p>	<p>ХасБанкны хөрөнгө оруулагчидтай харилцах харилцааг ХасБанкны санхүү хариуцсан захирал бөгөөд гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч хариуцан ажилладаг. Тэрээр тухай бүр гүйцэтгэх захиралтай зөвшилцөн хувьцаа эзэмшигчдэд чиглэсэн арга хэмжээг хөтөлбөр байдлаар тодорхойлж хэрэгжүүлэн ажилладаг. “ХасБанкны Засаглалын кодекc”-ийн 1-р хэсгийн 1-д банк нь хөрөнгө оруулагчидтай харилцахдаа ил тод, шударга, хариуцлагатай, ёс зүйтэй байх зарчмуудыг баримтлах, 3-р хэсгийн 2-т “санал хураалтад жижиг хувьцаа эзэмшигч, оролцогч талуудын эрхийг онцгойлон харгалзаж үзэх, Монголбанкны журмын дагуу ТУЗ-д хэд хэдэн хараат бус гишүүнийг томилох, холбогдох хууль тогтоомжид заасны дагуу үнэн зөв мэдээллийг тухай бүр авах эрхээ саадгүй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхийг чухалчилна. Бүх хувьцаа эзэмшигчийг эрхээ хэрэгжүүлж, шийдвэр гаргахад шаардлагатай буюу хангалттай мэдээллээр хангана” гэж тус тус заасан. Үүний дагуу хөрөнгө оруулагчидтай харилцах тусгайлсан утас (85081888) болон цахим шуудан (investor-relations@xacbank.mn)-г хэрэглээнд нэвтрүүлэн, түүгээрээ дамжуулан өөрийн хувьцаа эзэмшигчидтэй шууд харилцаж байна. Түүнчлэн, өөрийн цахим хуудсын “Хөрөнгө оруулагчид” хэмээх тухайлсан цэсээр дамжуулан хөрөнгө оруулагчдад мэдээлэл хүргэж байна.</p>	2	
34	<p>9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.</p>	<p>Бүрэн хэрэгжүүлсэн.</p>	<p>ХасБанк ХК-ийн Дүрмийн 6 дугаар зүйлд хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх зэрэг хууль ёсны эрхийг хамгаалан зохицуулсан. Энэ хүрээнд холбогдох хууль тогтоомж, дотоод дүрэм, журмын дагуу ажиллаж байна. Мөн хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл авах эрхийг хангах үүднээс нарийвчилсан журам болох “Мэдээллийг ил тод болгох ерөнхий журам”-ыг 2023 оны 7 сарын 07-ны өдөр шинээр батлан, түүний дагуу нийтэд мэдээлбэл зохих мэдээллийг тогтоосон хугацаанд мэдээлэн ажиллаж байна.</p>	2	

			ХасБанк нь хувьцаат компани болж өөрчлөн байгуулагдсаны дараах хувьцаа эзэмшигчдийн анхдугаар ээлжит бус хурлыг 2023 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр Шангри-Ла зочид буудлын хурлын танхимд, хувьцаа эзэмшигчдийн анхдугаар ээлжит хурлыг 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр тус тус цахим болон танхимын хосолсон хэлбэрээр зохион байгуулсан. Ингэхдээ Компанийн тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам” ХасБанкны “Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах үйл ажиллагааны журам”-ын дагуу хувьцаа эзэмшигчдэд хурлын зарыг түгээж, хуралд оролцох бололцоог бүрдүүлсэн. Тус хурлуудаар хувьцаа эзэмшигчид ХасБанкны аппликейшнийг ашиглан эсхүл биечлэн саналаа өгөх боломжийг бүрэн хангаж ажилласны зэрэгцээ хурлын материалуудыг өөрийн цахим хуудаст байрлуулж, түүнтэй танилцах бололцоог бүрдүүлсэн.		
35	9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтэцтэй холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.	Бүрэн хэрэгжүүлсэн.	ХасБанк ХК-ийн Дүрмийн 8.6 дахь хэсэгт Банкны үйл ажиллагааны чиглэл (банкны үйл ажиллагаанд аливаа өөрчлөлт оруулах), өмчлөлийн бүтэцтэй холбоотой асуудал (банкны хувь нийлүүлсэн хөрөнгийг өсгөх, бууруулах, хувьцааг хуваах эсхүл буцаан нэгтгэх, нийт гаргасан хувьцааны 5 (тав) хувиас дээш хувийг эргүүлэн авах зэргээр Банкны өөрийн хөрөнгийн бүтцэд аливаа мартерияллаг өөрчлөлт оруулах, нэмж хувьцаа, хувьцаанд хөрвөх аливаа төрлийн үнэт цаас гаргах гэх мэт)-ыг “Стратегийн ач холбогдол бүхий асуудал” хэмээн тодорхойлж, хуралд оролцож буй саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонх (66.67%-иас доошгүй хувь)-ийн саналаар батлах зохицуулалтыг тусгасан.	2	
36	9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн нийтлэг ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй	Бүрэн хэрэгжүүлсэн.	ХасБанк нь өөрийн ердийн үйл ажиллагааны хүрээнд бусад этгээдтэй хийх хэлцлээс хөнгөлөлттэй нөхцөлөөр сонирхлын зөрчилтэй этгээдтэй хэлцэл хийх, улмаар хувьцаа эзэмшигчдийн нийтлэг ашиг сонирхол зөрчигдөхөөс	2	

	хэлцэл хийх журамтай байх ба түүний хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.		сэргийлэх зорилгоор “Сонирхлын зөрчилтэй этгээд болон холбогдох этгээдтэй хэлцэл хийх журам”-ыг 2023 оны 7 сарын 07-ны өдөр шинээр баталсан (xacbank.mn -ээс үзнэ үү). Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийсэн мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу тухай бүр Монголын Хөрөнгийн Бирж болон өөрийн цахим хуудсаараа дамжуулан нийтэд мэдээлдэг бөгөөд Монголын Хөрөнгийн Биржийн (https://www.mse.mn/mn/confdeal/353) албан ёсны вебсайтад хандан танилцах боломжтой.	
Үнэлсэн оноо			10	100%
Нэгдсэн оноо			72	100%